

АЖЛЫН ХУУДАС 2

Эсээний хэсгийг уншаад даалгавруудыг ажиллаарай.

Цагаан зээрийн өдий хүртэл амьд оршсоор ирсний учир юун гэвэл хэнд ч гай болохгүй дэндүү мөрөөрөө явсных нь их буян бөлгөө. Хоёр өвс тааралдвал нэгийг нь, нэг өвс тааралдвал хагасыг нь үлдээж, тал нутгаа тал болгодоггүй элэг зөв амьтан шүү дээ.

Энэ амьтны "эрлэг номун хаан" нь дээхнэ үеийн цэргийн ангийн машин унасан цэрэг ахлагч нар байлаа. Тэд зээрийн сүрэг рүү байлдааны хүчирхэг буугаар гал нээж, цусанд нь будаж, зугаагаа гаргадаг байсан юм. Дорнод талд үе үе болдог энэ аллагын дараа эхийгээ босоод ирнэ гэж тормойтол хүлээх янзага, гэдсээ хөвүүлсэн, хөлөө санжуулсан эрэмдэг амьтдаар тал дүүрч, салхи ёолж, элэг эмтрэм эмгэнэл үлддэг сэн... Амьтны амийг таслахад худлаа ч гэсэн шалтаг гардаг бол зээрт хэлэх үг олдохгүй. Бэлчээр талхалсан, булаалдсан гэлтэй биш. Махыг хүнсэнд гэх боловч арвигүй энэ тураг махаар өвлийн идшээ базаадаг хүн гэж үгүй. Элдүүр даахгүй арьс нь гутлын ул үрэхэд ч нэмэргүй.

Цагаан зээрийг улаан зээр болтол хядах нь арай л элэг барьсан явдал юм.

Ж.Гангаа "Хялганат талын цагаан зээр хар цээр биш ээ"

2. Дараах хүснэгтэд тохирох жишээг эхээс олж байрлуулаарай.

Үндэслэл шалтгаан

Баримт

Зохиогчийн хандлага

Зохиогчийн сэтгэл хөдлөл

Зохиогчийн үзэл бодол

3. Аль нь зохиогчийн мэдрэмж сэтгэгдэл вэ? Яагаад

Зохиогчийн сэтгэл хөдлөл

Зохиогчийн үзэл бодол

Зохиогчийн хандлага

Яагаад гэвэл:

1. Цэгийн оронд тохирох үгийг эхээс олж бичээрэй

Тал, хээр нутагт сүрэглэн амьдардаг, салаа туурт, сүүгээр бойжигч амьтан (.....

толгой шийр, гэдэс дотроос бусад мах- (.....

Элгэмсүү дотно, санаа зөв- (.....

Бусдад гэм халгүй амьдрах- (.....